- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар";

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ерөнхий захирлын 2020 оны 05 дугаар сарын 28-ны А/54 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хяналт шалгалтын хэлтэс 2021 онд 11 дүгээр сард 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж 765,400.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж санхүүгийн сахилга батыг хэвшүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, төрийн өмчид бүртгэлээр тавигдах хяналт, шалгалтыг сайжруулах зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 40,872,423.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 408,724.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар 286,106.94 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,707,631.7 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансдын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 9.0 | 338,509.3 | 338,500.3 |
| Авлага | 76,728.1 | 5,588,884.9 | 5,512,156.8 |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 3,539,742.7 | 5,046,455.9 | 1,506,713.2 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 56,477,105.8 | 56,827,367.2 | 350,261.4 |
| **Нийт хөрөнгө** | **60,093,585.6** | **67,801,217.3** | **7,707,631.7** |
| Өр төлбөр | 74,561.9 | 3,030,448.1 | 2,955,886.2 |
| Өмч-төрийн | 19,625,186.5 | 19,625,186.5 | |
| Хуримтлагдсан үр дүн | 10,755,714.2 | 15,507,459.7 | 4,751,745.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 29,638,123.0 | 29,638,123.0 | |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **60,093,585.6** | **67,801,217.3** | **7,707,631.7** |

Дараах дансдын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 338,500.3 мянган төгрөгөөр өссөн;
- Авлагын данс 5,512,156.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМДС-гаас 5,442,040.7 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан;
- Бараа материалын дансны дүн 1,506,713.2 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмийн хэрэгслийн үнэ нэмэгдсэн мөн Ковид-19-ын улмаас зайлшгүй байлгах нөөц бүрдүүлснээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансанд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 156,400.0 мянган төгрөгийн 2 автомашин, хандив тусламжийн 5,998,603.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой;
- Өр төлбөр данс өмнөх оноос 2,955,886.2 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-гаас санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т орсон өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлээр санхүүжих болсон тул улсын төсвийн санхүүжилт буурч эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт өссөн.

Төсөвт байгуулагын өөрийн орлого үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан болон бусад газруудаас хандив тусламжаар олгосон эм бэлдмэл, эмийн хэрэгсэл бусад зүйлсийн орлоготой холбоотой байна. Цар тахлын үед ажилласан резидент эмч нарын урамшууллаар нэмэлт санхүүжилт өссөн.

Засгийн газрын 2019 оны 05 тоот тогтоолын дагуу олгосон 60 хүртэл хувийн үр дүнгийн урамшуулал, цар тахлын үед илүү цагаар ажилласан эмч, эмнэлгийн ажилтнуудад дэмжлэг үзүүлэхээр олгосон урамшуулал зэргээр цалингийн зардал өссөн. Нэг удаагийн тэтгэмж урамшуулал мөн жилийн эцэст олгосон урамшууллаар нэмэгдсэн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 42,102,775.6 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 42,046,075.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/16 тоот тушаалаар 35,103,468.4 мянган төгрөгөөр тайлант оны төсвийг баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсөв болон ЭМДС-гаас 34,299,517.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 803,950.6 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

2021 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн ЭМДҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03 тоот тогтоолыг мөрдөж улсын төсвөөс санхүүжиж байсан эмнэлгийн тусламж үйлчилгээнүүдийг ЭМДС-гаас санхүүжүүлэхээр ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах” 01/05 тоот гэрээний дагуу санхүүжилтийн

төлөвлөгөөг 34,299,517.8 мянган төгрөг баталсан байна. ЭХЭМҮТ-ийн баталсан төсөвт өөрчлөлт оруулах шийдвэр байхгүй байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд ЭМДС-гаас 31,763,893.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлого 633,758.2 мянган төгрөг, нийт 32,397,651.4 мянган төгрөгийн эх үүсвэрээс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээний гүйцэтгэлд 32,267,293.5 мянган төгрөгийг зарцуулж, 91.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

ЭМДС-гаас 39,571,828.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нэхэмжилснээс 37,205,933.9 мянган төгрөгөөр хянаж, санхүүжүүлсэн байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөр | 35,103,468.4 | 32,397,651.4 | 2,705,817.0 | 92.3 |
| 1.1 | 80101 | Үйл ажиллагааны зардал | 35,103,468,4 | 32,267,293.5 | 2,836,174.9 | 91.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Дээд шатны төсвийн захирагч буюу Эрүүл мэндийн яамнаас 3,331,315.0 мянган, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс өгсөн хандив 337,360.9 мянган, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 226,416.6 мянган төгрөг, нийт 3,895,092.5 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдсэн байна.

Нэмэлт төсвийн зарцуулалт 3,686,950.1 мянган төгрөгийн буюу 94.6 хувийн гүйцэтгэлтэй. Мөнгөн хөрөнгийн дансан дахь үлдэгдэл 208,142.4 мянган төгрөг, үүнээс резидент эмчийн болон төслийн цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлд 1,721,717.7 мянган, эрүүл мэндийн ажилтнуудын нэг удаагийн урамшууллад 1,478,720.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 486,512.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

### Асуудлыг онцолсон хэсэг:

Тайлант онд ЭМЯ-аас төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар нийт 5,429,546.0 мянган төгрөгийн өртөгтэй 385 тоног төхөөрөмж хөрөнгийг хүлээн авч, худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 12,043,448.1 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ худалдаж авахаар гэрээ байгуулсан байна.

Тус эмнэлэг нь 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 41,863.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдаж авсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй байна.

Тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 26 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас гүйцэтгэлээр 99.6 хувьтай гэж тайлагнасан байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.3 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв гүйцэтгэлээр санхүүжсэн.

ЭМДС-гаас 39,571,828.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нэхэмжилснээс 37,205,933.9 мянган төгрөгөөр хянаж, ЭМДҮЗ-ийн 03 тоот тогтоолын дагуу цахим системийн тохируулгаар 1,626,500.0 мянган, нэхэмжлэлийн шаардлага хангаагүй 134,595.0 мянган, ковидын тусламж үйлчилгээний зардлыг буруу нэхэмжилсэн 410,400.0 мянган төгрөг, нийт 2,171,495.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг шаардлага хангаагүй гэж тооцсон байна.

Иймд ЭХЭМҮТ өөрийн хүчин чадлаар ажиллаж үзүүлсэн тусламж, үйлчилгээний 2,171,495.0 мянган төгрөгийг авах боломжийг алдсан байна. Цахим системийн тохируулга, хяналтаар хасагдсан 1,626,500.0 мянган төгрөгийг системийн алдаанаас болсон гэж үзсэн байна. Тус сангаас 5,442,040.7 мянган төгрөгийн авлагатай байна.

ЭМДС-д ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 тоот тогтоолын дагуу цахим системээр нэхэмжлэлийг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангуулах талаар тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

*<u>Илрүүлэлт:</u>* Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2021 онд нийт орлогын 43,012.752.5 мянган төгрөгийн 270 мэдээлэл, зарлагын 12,647,387.9 мянган төгрөгийн 415 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийг хугацаа хоцроож, 72,792.6 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 3 дугаар зүйл 3.1.1, 3.1.2 хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу 133 багц 12,043,448.1 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт, 4 багц 135,413.0 мянган төгрөгийн харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах тендер, нийт 12,178,861.1 мянган төгрөгийн цахим тендерийг хугацаанд нь зарласан байна.

Тендер шалгаруулалтын үр дүнгээр нийт 12,032,294.2 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулагдсан. Худалдан авах ажиллагаатай холбоотой 4 гомдол гарсныг Сангийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар хянаж шийдвэрлэсэн байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 2,770,822.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,750,761.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 20,060.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санхүүгийн программын хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх ажил сайжруулах 4 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 4 | 120,824.6 | 4 | 120,824.6 | - | - | 100 |
| Зөвлөмж | 2 | 361,633.4 | 2 | 361,633.4 | - | - | 100 |
| **Нийт дүн** | **6** | **482,458.0** | **6** | **482,458.0** | **-** | **-** | **100** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“ЭХЭМҮТ-ийн техник технологийг шинэчлэх Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн төсөл”-ийн хүрээнд 33 нэр төрлийн 432 бараа, үйлчилгээ нийлүүлэхээр тусгасан байна. Австрийн Засгийн газрын төслийн хүрээнд “Ур чадварын өрөө”-г хүүхдэд үзүүлэх суурь ба лавшруулсан сэхээн амьдруулалтын сургалт хийх орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Тус өрөөг 2021 оны 10-р сарын 19-нд хүлээн авсан.

Соронзон резонанст томографийн өрөө ба суурилуулалт, хүүхдийн эмнэлзүйн симуляцийн тоног төхөөрөмжийн 6 багц тоног төхөөрөмж item 1, 32, 10a, 10c, 13a, 16 эдгээр тоног төхөөрөмжүүд нь бүрэн угсралт суурилуулалт хийгдэж дуусаагүй байна.

Эдгээр хөрөнгө болон засварыг бүрэн хүлээн аваагүй тул санхүүгийн тайланд тусгаагүй байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/233 тоот тушаалын дагуу тус төвийн мэдрэл, нярай, мэдээгүйжүүлэг хагалгааны өрөөний их засварт 674,000.0 мянган төгрөг, эмчилгээний хоол судлалын тасгийн их засварын 186,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрх шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн боловч улсын комисс хүлээж аваагүй шалтгаанаар 2021 оны санхүүгийн тайланд тусгаагүй байгаа хөрөнгө оруулалтын засварын ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар анхаарч санхүүгийн тайланд тусгуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,575,937.1 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,187,562.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 388,374.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Нийт 1,575.937.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшингээс 1,167,212.9 мянган төгрөгөөс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 4.1 Албан шаардлага

*Илрүүлэлт:* ЭМДЕГ нь ЭМДҮЗ-ийн 03 тоот тогтоолын дагуу нэхэмжлэлийн шаардлага хангаагүй 134,595.0 мянган төгрөг, ковидын тусламж үйлчилгээний зардлыг буруу нэхэмжилсэн 410,400.0 мянган төгрөг, нийт 544,995.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг шаардлага хангаагүй гэж санхүүжилтээс хасагдсан нь үзүүлсэн тусламж, үйлчилгээний орлого олох боломжийг алдсан байна. Энэ нь тус төвийн эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтны хариуцлагагүй, дотоод хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.2 болон ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 тоот тогтоолыг бүрэн судалж, хэрэгжүүлж ажиллаагүй ба эрх үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЭМДҮЗ-ийн 03 тогтоолын шаардлагыг хангасан нэхэмжлэх хүргүүлж байх, ажлын хариуцлагыг сайжруулах албан шаардлага өгөх.

*Илрүүлэлт:* Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/16 тоот тушаалаар баталсан төсвийг 642,567.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 35,746,036.2 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Шийдвэргүйгээр төсвийг нэмэгдүүлсэн, төсөвт хяналт тавих Төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.11 “Төлөөлөн удирдах зөвлөл дараахь үүрэгтэй байна”, 17.11.3 “эмнэлгийн тухайн жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих” гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн тухайн хуулийн заалтыг биелүүлж төсвийг бүрэн хянаж ажиллах Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах албан шаардлага өгөх.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Өглөг, авлагатай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайланд тусгасан 159,731.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 992,147.8 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаас 77,268.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3 бүх өр төлбөр; 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. *Зардлын ангилал зөрчсөн асуудал*

*Илрүүлэлт:* Санхүүгийн үр дүнгийн тайланд тээвэр шатахууны зардалд сэлбэг хэрэгслийн зардлын 19,836.0 мянган, хог хаягдал зайлуулах зардалд түлш халаалтын зардлын 45,492.1 мянган, бичиг хэргийн болон сэлбэг хэрэгслийн материалын зардал 20,732.7 мянган төгрөг, нийт 86,080.8 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллыг зөрчиж тайлагнасан байна.

*Өгсөн зөвлөмж:* Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах;

3. *Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө худалдаж авсан асуудал*

*Илрүүлэлт:* 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 41,863.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдаж авсан нь ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна гэж заасныг биелүүлж ажиллах;

4. *Жолооч нарын тооцооны асуудал*

*Илрүүлэлт:* Нягтлан бодогч жолооч нарын тооцоог боддоггүй, түлш шатахууны хэмнэлт хэтрэлтийг тооцоогүй, нийт дүнгээр зардалд бичсэн, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг журналд бичсэн, нийт 23,430.0 мянган төгрөг байна.

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны маягт хөтлөх зааварын 6-4 т "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаархи гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэж заасныг биелүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зөвлөмж | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | |
| 1 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | Санхүүгийн үр дүнгийн тайланд тээвэр шатахууны зардалд сэлбэг хэрэгслийн зардлаас 19,836.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардалд түлш халаалтын зардлын 45,492.1 мянган төгрөг, бичиг хэргийн болон сэлбэг хэрэгслийн материалын зардал 20,732.7 мянган төгрөгийг тус тус зардлын ангиллыг зөрчиж тайлагнасан байна. | Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөх | 1 | 86,080.8 | 1 | 86,080.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | ЭМДҮЗ-ийн 03 тоот тогтоолын дагуу нэхэмжлэлийн шаардлага хангаагүй 134,595.0 мянган төгрөг, ковидын тусламж үйлчилгээний зардлыг буруу нэхэмжилсэн 410,400.0 мянган төгрөг нийт 544,495.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг шаардлага хангаагүй гэж санхүүжилтээс хасаж хянасан. Иймд ЭХЭМҮТ өөрийн хүчин чадлаар ажиллаж үзүүлсэн тусламж, үйлчилгээний 544,495.0 мянган төгрөгийн орлогыг авах боломжийг алдсан байна | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.2, 11.3 заалтыг мөрдөх | 1 | 544,995.0 | | | | | 1 | 544,995.0 | | |
| 3 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 41,863.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдаж авсан нь ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1 заалтыг мөрдөх | 1 | 41,863.8 | 1 | 41,863.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | Батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн тушаал шийдвэр байхгүй, түүнд хяналт тавих төлөөлөн удирдах зөвлөл байгуулж Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д заасан заалтыг биелүүлээгүй батлагдсан төсөвт тавих хяналт байхгүй тул тушаал шийдвэргүйгээр төсвийг нэмэгдүүлсэн байна. | Төсвийн тухай хууль 9 дүгээр зүйл 9.1.4, 10 дугаар зүйл 10.1.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.7 заалтыг мөрдөх | 1 | 642,567.8 | | | | | 1 | 642,567.8 | | |
| 5 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | Нягтлан бодогч жолооч нарын тооцоог боддоггүй, түлш шатахууны хэмнэлт хэтрэлтийг тооцоогүй нийт дүнгээр зардалд бичдэг, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт байхгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг журналд бичсэн | Нягтлан бодох бүртгэлийн тхай хууль 12 дугаар зүйл. 12.2.1, 12.2.2, 12.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 заалтыг мөрдөх | 1 | 23,430.0 | 1 | 23,430.0 | | | | | | |
| 6 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | Санхүүгийн тайланд тусгагдсан эмийн өглөгөөс 159,731.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 992,147.8 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаасаа 77,268.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | Нягтлан бодох бүртгэлийн тхай хууль 14 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх 14.4.1, 14.4.2, 14.4.3, 14.4.4, 14.4.5, 14.4.6, 14.4.7 заалтыг мөрдөж ажиллах | 1 | 236,999.7 | 1 | 236,999.7 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | | | | | **6** | **1,575,937.1** | **3** | **388,374.3** | **0** | **0** | **3** | **1,187,562.8** | **0** | **0.0** |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | |
| 1 | ЭХЭМҮТ | АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн шалгах үүднээс ЭХЭМҮТ-ийн мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг ерөнхий журналтай тулган " Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журмын дагуу шалгалаа. ЭХЭМҮТ-ийн үйл ажиллагааны хувьд нийт 957 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг огт оруулаагүй байна. | Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 3 дугаар зүйл 3.1.1, 3.1.2 заалтыг мөрдөх | 1 | 72,792.6 | | | | | | | 1 | 72,792.6 |
| **Дүн** | | | | | **1** | **72,792.6** | | | | | | | **1** | **72,792.6** |
| **Нийт дүн** | | | | | **7** | **1,648,729.7** | **3** | **388,374.3** | **0** | **0** | **3** | **1,187,562.8** | **1** | **72,792.6** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 181/А01500571 Улаанбаатар хот
АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төсвийн тухай хууль 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 20 мэдээллийг хугацаа хоцроож, 72,792,592.00 төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ, 3 дугаар зүйл 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2 төрийн өмчит үйлдвэрийн газар, хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй эм, эмийн хэрэгсэл хариуцсан нягтлан бодогч П.Одмаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Алтантуяа, ахлах нягтлан бодогч Г.Оюун-эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-167.Docx

0010800529

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 182/A0150054 Улаанбаатар хот

АХГ-2022/382/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нэхэмжлэлийн хяналтаар "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл"-ийн 03 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт "Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам", "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж, үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд баримтлах удирдамж"-ын шаардлага хангаагүй тус төвийн үзүүлсэн тусламж үйлчилгээний нийт 544,995,000.00 төгрөгийн санхүүжилтийг хасаж хянасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.2 "Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно" гэж заасны дагуу гарсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолд заасныг *хэрэгжүүлж ажиллаагүй,* байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулж, "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл"-ийн 03 дугаар тогтоолын шаардлагыг хангасан нэхэмжлэлийг хүргүүлж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Алтантуяа, Эдийн засаг, санхүүжилтийн тасгийн эрхлэгч Д.Хонгорзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА

АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХМАА

9006109

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 183/А0150054 Улаанбаатар хот

АХГ-2022/382/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хууль 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/16 дугаар тушаалаар баталсан төсвийг 642,567,800.00 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна.” 17.11 “Төлөөлөн удирдах зөвлөл дараахь үүрэгтэй байна” 17.11.3 “Эмнэлгийн тухайн жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих” гэж заасныг биелүүлээгүй, заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тухайн хуулийг биелүүлж, төсвийн зохицуулалтыг бүрэн хянаж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Алтантуяа, ахлах нягтлан бодогч Г.Оюун-эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХМАА

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-166.Docx

0010800527

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ